Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо [1]	Хувийн жин [2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал [7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал [8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал [9]	0,5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**3.5**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал [11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал [12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал [13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9.5**	**95**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

-oOo-

БАТЛАВ.
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ж.МӨНХ-ОРГИЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хугацаа
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ЗГ-ын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г албан хаагчдад таниулах, шинэ албан хаагчдын сургалтыг ЗУГ-тай хамтран зохион байгуулах	УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/”-ийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Ёс зүйн хорооноос тогтоосон сургалтын агуулга хөтөлбөрийн дагуу албан хаагчдад сургалт зохион байгуусан байна.	Хагас жилд нэг удаа
2	Байгууллагын соёлыг сайжруулах	Соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалт, аян зэргийг зохион байгуулсан байна.	Жилдээ
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар гаргасан өргөдөл, гомдлыг хянах дараалалыг өөрчлөх	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн дагуу өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсэн байна.	Тухай бүр
4	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг холбогдох эрх бүхий этгээдэд хүргүүлсэн байна.	2026 оны 1 дүгээр сард

---oOo---

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН “ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний 560 дугаар тушаалаар “Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Ёс зүйн дэд хороо”-г 7 гишүүний бүрэлдэхүүнтэй 5 жилийн хугацаатай байгуулсан. Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 онд байгууллагын захиргааны нэгжтэй хамтран төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хүрээнд 4 төрлийн сургалт, холбогдох асуумж бөглүүлэх, мэдлэг олгох тест ажиллуулах зэрэг нөлөөллийн дараах нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Байгууллагын ажилтнуудын санал, хүсэлтийг үндэслэн цэцэрлэг, сургуулийн хүүхэд хүлээн авах цагийн хуваариас шалтгаалж бага насны хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэдэг зарим албан хаагчидтай ярилцлага хийж, бодит нөхцөл байдлыг тогтоон зайлшгүй шаардлагатай гэж үзсэн албан хаагчдын ажлын цагийн ирэх, явах цагт өөрчлөлт оруулах саналыг Томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Иргэдээс гаргасан болон албан хаагчдаас гаргасан санал, хүсэлтэд үндэслэн ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын соёлыг сайжруулах хүрээнд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчтэй утсаар харилцах зөвлөмжийг албан хаагч бүрт хүргүүлж, мөн өрөө бүрт байршуулсан. Мөн төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбогдуулан гомдлыг хянан шийдвэрлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчтай холбоотой 2 гомдлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд хүлээн авч хянан шийдвэрлэсэн байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт алба хаагчдын дунд ажлын байрны иж бүрэн судалгааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн дотоод зохион байгуулалтыг хийж хэрэгжүүлж байна. Мөн албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдаас саналыг авч, холбогдох дүн шинжилгээг хийж үе шаттай сургалтуудыг тухайн чиглэлээр мэргэшсэн сургагч багш нараар удирдуулан зохион байгуулсан.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

1. Өдөр тутам иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хүлээн авдаг, хяналт шалгалт гүйцэтгэдэг албан хаагчдыг ёс зүйн зөрчил, маргаанд өртөх магадлал харьцангуй өндөр албан хаагчдад зориулж иргэн, үйлчлүүлэгчтэй харилцах чадварыг нэмэгдүүлэх, ажлын орчныг сайжруулах хүрээнд "Оксфордын санамсрын бясалгал" сургалт;

2. Албан хаагчдыг иргэн, хуулийн этгээдтэй харилцахад бодлого зохицуулалтын шалтгаан нөхцөлийг оновчтой таниулах чадварыг нэмэгдүүлэх хүрээнд "Илтгэх ур чадвар" сэдэвт сургалт;

3. Албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд "Аз жаргалтай ажлын байр" сэдэвт сургалт.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Томилох эрх бүхий албан тушаалтны хувьд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ЗГ-ын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г чанд мөрдөн ажиллаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, албан хаагчдад үлгэр дуурайлал үзүүлэх, манлайлах хүрээнд Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан сургалтад идэвхтэй хамрагдахаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ.

Шударга томилгоо, мерит зарчмын хэрэгжилт

Сул гарсан ахлах түшмэлийн 6, эрхэлсэн түшмэлийн 5 орон тоог нөхөхтэй холбогдуулан шалгалтыг зохион байгуулахдаа албан тушаалд томилох, дэвшүүлэх үйл ажиллагаанд мэдлэг, чадвар, туршлага, ажлын гүйцэтгэлээс гадна ёс зүй, сахилга хариуцлагын байдлыг харгалзан мерит зарчмыг баримталж, ил тод шалгуур, журмыг мөрдөн өөрийн байгууллагын албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасан шаардлагыг хангасан албан хаагчдаас шатлан дэвшүүлэх саналыг гаргасан бөгөөд уг албан хаагчид нь төрийн албаны тусгай шалгалтад тухай бүр хамгийн өндөр оноог авч томилогдсон байна.

Ёс зүйн соёлыг төлөвшүүлэх арга хэмжээ

Байгууллагын хэмжээнд ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, ёс зүйн дүрэм, хэм хэмжээг сурталчлах, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажилласан. Ёс зүйн зөрчил мэдээлэх, шийдвэрлэхэд ил тод, нээлттэй орчныг бүрдүүлэхэд удирдлагын түвшинд дэмжлэг үзүүлэн цахим болон цаасан зэрэг бүхий л сувгаар мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэн ажилласан.
Мөн түүнчлэн байгууллагын Ёс зүйн дэд хороо болон Захиргааны нэгжээс ирүүлсэн саналыг харгалзан байгууллагын албан хаагчдад зориулсан 4 төрлийн сургалтад шаардагдах санхүүжилтийг төсөвт тусган санхүүжүүлсэн бөгөөд цаашид тогтмол зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан 2025 онд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хүрээнд:

Иргэдээс гаргасан болон албан хаагчдаас гаргасан санал, хүсэлтэд үндэслэн ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын соёлыг сайжруулах хүрээнд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчтэй утсаар харилцах зөвлөмжийг албан хаагч бүрт хүргүүлж, мөн өрөө бүрт байршуулсан.

Байгууллагын албан хаагчдаас төрийн албан хаагчийн ёс зүйг сайжруулах, соён гэгээрүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд саналыг авч, холбогдох дүн шинжилгээг хийж үе шаттай сургалтуудыг байгууллагын захиргаа удирдлагын нэгжтэй хамтран тухайн чиглэлээр мэргэшсэн сургагч багш нараар удирдуулан дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

1. Байгууллагын хүйсийн харьцаа 70:30 буюу аль нэг хүйсийн төлөөлөл давамгайлах шинж байдал үүсэж байгаатай холбогдуулан, мөн жендертэй холбогдох ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар “Төрийн албан хаагчийн ёс зүй ба жендерийн мэдрэмж” сургалт;
2. Шинэ албан хаагчийн чиглүүлэх сургалтын хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж” сургалт.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн байдлын талаар:

2025 онд Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчтай холбоотой 2 гомдлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд хүлээн авч дараах байдлаар хянан шийдвэрлэсэн байна.

1.СЗХ-ны холбогдох албан хаагч нь зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлүүлэхгүй үндэслэлгүйгээр өөртөө удааж сар гаруй хугацааны дараа шийдвэрлэсэн талаарх гомдол ирүүлснийг хянан үзэхэд холбогдох албан тушаалтан Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрлийн хүсэлтийг албан тушаалтан ажлын 5 өдөрт магадлан шалгаж, эрх бүхий албан тушаалтан ажлын 5 өдөрт зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх хугацааны хүрээнд буюу тухайн гомдолд холбогдсон албан хаагч нь ажлын 3 өдрийн дотор зөвшөөрлийн хүсэлтийг магадлан шалгаж, улмаар дээд шатны албан хаагчид хянуулахаар шилжүүлж, тухайн зөвшөөрөл нь ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэгдсэн байсан тул гомдлыг үндэслэлгүй гэж үзсэн.

2.СЗХ-ны албан хаагч нь хууль зөрчин зөрчлийн хэрэг нээж төрийн албан хаагчийн ёс зүйг зөрчсөн талаарх гомдлыг хүлээн авч хянан үзэхэд тухайн асуудал нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу холбогдох прокурорын байгууллага шийдвэрлэх зохицуулалттай байсан тул ёс зүйн дэд хороо харьяаллын дагуу шилжүүлсэн байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдаж тухайн асуудал эрх зүйн зохицуулалттай болсноор байгууллагын хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг үе шаттай тогтмол зохион байгуулдаг тогтолцоо бий болсон байна.	Хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх харьяаллын талаар иргэд мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалж ёс зүйн зөрчилтэй холбоогүй гомдлыг ёс зүйн дэд хороонд гаргах асуудал анзаарагдаж байна. Жишээлбэл Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэгт шалгагдаж буй этгээдээс хянан шалгаж буй эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой гомдлыг харьяалах прокурорт биш ёс зүйн дэд хороонд гаргах гэх мэт.
Санал:	
Ёс зүйн хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд таниулах ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг хэрхэн гаргах талаарх контент, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	

Шалгах хэсэг:

☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Ажлын албаны ДАҮТОГ С.Цогтгэрэл .....

Ёс зүйн дэд хорооны дарга

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил .....

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Лхагвасүрэн .....

Огноо: 2025 оны 01 сарын 13